



Канадын Жендэрийн дүн шинжилгээ⁺

MERIT төслийн зөвлөх, Мишэл Филион

Агуулга

- Хүйс ба жендэр
- “Нэмэх тэмдэг”-ийн тайлбар
- Заавал биелүүлэх хариуцлага
- Хэрэгжилтийн тогтолцоо

Хүйс ба жендэр


- Хүйс ба жендэрийн тодорхойлолтыг хооронд холин сольж буруугаар ашиглах нь олонтаа тохиолддог.
- Төрөөс санаачилж буй бодлого хөтөлбөрийн үр нөлөө, өгөөжийг тодорхойлохыг хүсч байвал эдгээрийг сайтар ялган салгаж ойлгон, нухацтай авч үзэх хэрэгтэй.
- Та аль нэг нь л нөлөөлөхүйц хүчин зүйл болно гэж тооцож болох ч заримдаа эсрэгээрээ байж болно.

Хүйс ба жендэр, “нэмэх тэмдэг”-ний тайлбар

Бүх хүнийг эрэгтэй, эмэгтэй эсвэл эршүүд, эмэгтэйлэг гэж хүйс, жендэрийнх нь хувьд ангилан хоёр цул ойлголтоор тодорхойлох боломжгүй. Жендэрийн дүр төрхийн талаарх асуудлыг Канадад төдийгүй дэлхий даяар чухлаар авч үзэж, олон яриа хэлэлцүүлэг өрнөж байна. Хүйс, жендэр болоод эдгээр нэршлийг хэзээ, хэрхэн ашиглах талаар бидний ойлголт ч хувиран өөрчлөгдөж байна.

“Нэмэх тэмдэг”-ний тайлбар

- Жендэрийн дүн шинжилгээ⁺ нь зөвхөн жендэрийн тухай биш бөгөөд нийгмийн бүлгүүд ч гэсэн нэг хэвэнд цутгасан мэт адилхан байдаггүй.
- Бидний хэн бэ гэдгийг тодорхойлдог харилцан хамаарал бүхий олон хүчин зүйл буюу хүн ам, нийгмийн үзүүлэлтүүд байдаг.
- Энд дурдагдсан “**нэмэх тэмдэг**” нь ЖДШ нь үргэлж хүйс, жендэрээс хальсан хүн ам, нийгмийн үзүүлэлтүүдийг авч үздэгийг илтгэж буй хэрэг юм. Шинжилгээ нь хүйс, жендэр нь яс үндэс, гарал угсаа, шашин, нас, сэтгэцийн болон бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэрэг бусад хүнийг тодорхойлогч хүчин зүйлээс хэрхэн хамаарч, харилцан нөлөөлж буйг анхаарч үздэг байна.



Заавал биелүүлэх хариуцлага

- Холбооны бүх албан хаагч төрийн бодлого, хөтөлбөр боловсруулахдаа өөрсдөөсөө зарим наад захын асуултыг асууж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өөр хүйсийн хүмүүс зэрэг нийгмийн олон бүлгийн талаарх өөрийн өрөөсгөл үзэл таамаглалыг сөрөн зогсох замаар уг дүн шинжилгээг ажилдаа нэвтрүүлэх үүрэгтэй. ЖДШ⁺-г ажилдаа системтэйгээр ашиглах замаар холбооны Засгийн газрын албан хаагчид асуудлыг олон өнцгөөс нь харж, ажлаа сайжруулах боломжтой болсон юм.

Хэрэгжилтийн тогтолцоо

- Цахим сургалт;
- Зөвлөн туслах;
- Бодлого;
- Энэ чиглэлийн ажил, түүний үр дүнг нь бүртгэх хариуцлага хүлээлгэх зэрэг багтана.

Merci.
